

ХЗС-ийн Захиргааны зөвлөлийн 2016 оны 3 сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцэж батлав.

МУИС-ийн ХЗС-ийн багш нарын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих тухай түр журам

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1. МУИС-ийг 2024 он хүртэл хөгжүүлэх стратегийн Зорилт 1.1. Судалгаа тогтмол хийдэг тэргүүлэх судлаач эрдэмтдийн тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Хэрэгжүүлэх стратеги 2-т “Багшийн судалгааны ажлыг дэмжсэн зохион байгуулалт, үнэлгээ, урамшуулал, хяналтын системийг бий болгох” гэснийг; ХЗС-ийн стратеги төлөвлөгөөний Бүрэлдэхүүн сургуулийн зорилго 1.1.1.-д заасан зорилтын хүрээнд ХЗС-ийн багш нарын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, үр дүнг дээшлүүлэх, олон улсын түвшинд хүргэхийн тулд тэдний эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор энэхүү түр журмыг гаргаж байна.
- 1.2. Энэхүү журам нь Хууль зүйн сургуулийн үндсэн багшид хамааралтай.
- 1.3. Энэхүү журмыг буцаан хэрэглэхгүй бөгөөд МУИС-ийн Багшийн хөгжлийг дэмжих сангийн журам гартал хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Эрдэм шинжилгээний ажлыг дэмжих хэлбэр

- 2.1. Дараах дэмжлэгийг сургуулийн захиргаанаас олгоно. Үүнд:
 - а. Гадаадын нэр хүнд бүхий хянан магадлагаатай мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэхэд шаардагдах хураамж;
 - б. Хянан магадлагаатай олон улсын мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэхэд гарсан орчуулгын редакцийн зардал;
 - в. Нэр хүнд бүхий олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцож илтгэл хэлэлцүүлэхэд олгох замын зардал.
- 2.2. Гадаадын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэхэд шаардагдах хураамжийг тухайн сэтгүүлд хэвлүүлэх албан ёсны зөвшөөрлийг үндэслэн олгоно. Хураамжийн хэмжээ нь тухайн сэтгүүлийн тогтоосон хэмжээгээр тодорхойлогдоно.
- 2.3. Гадаадын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэхэд гарсан орчуулгын редакцийн хөлсийг өгүүлэл хэвлэгдсэний дараа холбогдох нотлох баримтыг үндэслэн олгоно. Орчуулгын редакцийн хөлсийг А4 хэмжээний бүтэн нүүрээр 20 хүртэл хуудсанд нэг хуудсыг 25000 /хорин таван мянга/ төгрөгөөр тооцно.
- 2.4. Олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэхэд олгох замын зардлыг хурлын албан ёсны урилга, хөтөлбөр, илтгэлийг үндэслэн олгоно.
- 2.5. Нэг өгүүлэлийг 2 болон түүнээс дээш сэтгүүлд хэвлүүлэх, нэг илтгэлийг 2 болон түүнээс дээш удаа олон улсын хуралд хэлэлцүүлэх тохиолдолд сэтгүүлийн хураамж, орчуулгын редакцийн хөлс болон замын зардлыг дахин олгохгүй.
- 2.6. Дэмжлэг авах хүсэлтэй багш өргөдлөө холбогдох санхүүгийн болон бусад нотлох баримтын /өгүүлэл хэвлэгдсэн эрдэм шинжилгээний сэтгүүл, эсхүл хэвлэгдсэн гэдгийг батлах бусад баримт, хэвлүүлэх тухай сэтгүүлийн

редакцын зөвшөөрөл, хурлын албан ёсны урилга, хөтөлбөр, хэлэлцүүлэх илтгэл г.м./ хамт ХЗС-ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захиралд гаргана.

Гурав. Дэмжлэг олгох

- 3.1. Багш дэмжлэг хүссэн өргөдлийг нотлох баримтын хамт харъяалах тэнхимийн эрхлэгчид гаргах бөгөөд эрхлэгч багшийн өргөдлийг өөрийн саналын хамт сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захиралд хүргүүлнэ.
- 3.2. Дэд захирал өргөдөл, саналыг Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах бөгөөд дэмжигдсэн тохиолдолд Захирлын тушаал гарна.
- 3.3. Эрдэм шинжилгээний ажлын дэмжлэгийн зардлыг ХЗС-ийн багшийг дэмжих үйл ажиллагааны зардлаас гаргана.
- 3.4. Дэмжлэг авсан багш холбогдох санхүүгийн баримтыг сургуулийн санхүү эрхэлсэн ажилтанд хүлээлгэн өгнө.
- 3.5. Санхүүгийн болон бусад холбогдох нотлох баримтыг өгөөгүй, хуурамч баримт өгсөн нь дэмжлэг олгохоос татгалзах, олгосоныг буцаан авах үндэслэл болно.